



МОН БИЙФ ХК

ТАВАН БОГД ТРЕЙД ХХК

Таван Богд Төв байр
10-р давхар, ХААН Банк цамхаг
Чингисийн өргөн чөлөө-6, Стадион Оргил-1
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар 17010, Монгол Улс
Утас: 976-75112222, Факс: 976-11-345223
Электрон шуудан: info@tavanbogd.com
Вэб хуудас: www.tavanbogd.com

2023.02.03 № 01А-61

танай _____ -ны № _____ -т

Хувьцаа худалдан авах санал
гаргаж буй тухай

“Таван Богд Трейд” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хувьцаат компанийн хувьцаа худалдан авах журам”-ын 2 дугаар зүйлийг үндэслэн өөрийн охин компани болох “Мон Бийф” ХК-ийн нийт 44,200,000 ширхэг энгийн хувьцааг сайн дурын үндсэн дээр худалдан авах саналыг нийт хувьцаа эзэмшигчдэд гаргаж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Хавсралтаар: Хувьцаа худалдан авах санал. 2 хуудас.

Банкны баталгаа. 1 хуудас.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01/ТУЗ-01 тогтоолын хуулбар.
1 хуудас

ДОТООД АУДИТ
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Ц.ОЮУНЦЭЦЭГ

**МОН БИЙФ ХК-ИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН
АВАХ САНАЛ.**

№	Агуулга	Мэдээлэл
1	Санал гаргагч	Хуулийн этгээд: Таван Богд Трейд ХХК.
		Улсын бүртгэлийн дугаар: 9011010130
		Регистрийн дугаар: 2543303
		Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө 6, Стадион Оргил 1, Хаан банк цамхаг, 10 давхар 1001 тоот
		Холбоо барих утас: 75112222
2	Худалдан авах саналын эхлэх өдөр:	2023/02/03-ны өдөр 09:00 цаг
	Худалдан авах саналын дуусах өдөр:	2023/03/15-ны өдөр 18:00 цаг
3	Худалдан авахаар зарласан нийт хувьцааны тоо ширхэг:	44,200,000
4	Худалдах саналыг хүлээн авах өдөр:	2023/03/15-ны өдөр 18:00 цаг
5	Хувьцааг худалдан авах төлбөрийг гүйцэтгэх өдөр:	2023/03/17-ны өдөр, 13:00 цаг.
6	Худалдан авах санал гаргагчийн компанид эзэмшиж байгаа хувьцааны тоо хэмжээ, хувь:	116,261,045 ширхэг 54.26 хувь /2022 оны аудитлагдсан санхүүгийн тайланд тусгагдсан дүн/ 130,761,789 ширхэг 61.02 хувь /2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар/
7	Санал гаргагч болон холбогдох этгээд өөр компанийн хувьцааг эзэмшиж байгаа эсэх:	Хавсралтаар хүргүүлэв.
8	Худалдан авах санал гаргах болсон шалтгаан, зорилго:	Хувьцаа эзэмшигчдийн өмнө сайн дураар ёс зүйн болон санхүүгийн хариуцлага хүлээх
9	Нэгж хувьцааг худалдан авахаар санал болгох үнэ:	47 төгрөг
10	Санал гаргагчийн харилцагч үнэт цаасны компанийн холбогдох утас:	72727282
11	Худалдан авах санал гаргагчийн худалдах саналыг хүлээн авах шуудангийн хаяг	cf@tavanbogdcapital.com ,

ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Ц.ОЮУНЦЭЦЭГ

Таван Богд Трейд ХХК болон Холбогдох этгээдийн хувьцаа эзэмшиж буй компаниудын нэрс:

Д/д	Компаниудын нэрс
1	Таван Богд Трейд ХХК
2	Таван Богд Интернэйшнл ХХК
3	Таван Богд Дистрибьюшн ХХК
4	Монгол Машин Концерн ХХК
5	Таван Богд ХХК
6	Эйрлинк Монголиа ХХК
7	Улаанбаатар Гурил ХХК
8	Жуулчин ХХК
9	Жуулчин Дюти Фрий ХК
10	Файв Старс Ин Хархорин ХХК
11	Таван Богд Монгол Грилл ХХК
12	Хаан Палас ХХК
13	Сэргэлэн Резорт ХХК
14	Таван Богд Фүүдс ХХК
15	Таван Богд Авто Маркет ХХК
16	Таван Богд Фүүдс Пицца ХХК
17	Улаанбаатар Принт ХХК
18	Фүүд Сервис Солюшнс ХХК
19	Таван Богд Солюшнс ХХК
20	Таван Богд Проперти ХХК
21	Таван Богд Хаус ХХК
22	Таван Богд Резиденс ХХК
23	Мон Бийф ХХК
24	Таван Богд Финанс ББСБ ХХК
25	Таван Богд Капитал ҮЦК ХХК
26	Таван Богд Билдинг Саплай ХХК
27	Таван Богд Мон Мийт ХХК
28	Таван Богд Тэтгэврийн Хуримтлал ХХК
29	Таван Богд Моторс ХХК
30	Гэрлүг Виста сервис ХХК
31	Утаагүй орчин ХХК
32	Дата Бэйнк ХХК
33	Ток Ток ХХК
34	Тэмүүжин цогцолбор ХХК
35	Жуулчин Туризм Корпорейшн ХХК
36	Говь ХК
37	Замайн сервисес ХХК
38	Хаан банк ХХК
39	Ар И Ди Эженси ХХК
40	Саппирт Сервисиз Монголиа ХХК
41	Гурван сээр ХХК
42	Баялаг Хүчтэн ХХК
43	Шаазгайн нуруу ХХК



"ТАВАН БОГД ТРЕЙД" ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 21/093-01

Улаанбаатар хот

Санал гаргах эрх олгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16, 76.1.18 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мон Бийф” ХХК-ийн борлуулалт, ашигт ажиллагаа, үйлдвэр барих ажлуудын гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байгаа тул “Таван Богд Трейд” ХХК-ийн зүгээс бусад хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээж, хувьцааг худалдан авах санал гаргахаар шийдвэрлэсүгэй.
2. Тогтоолын 1 дүгээр хэсэгт заасан саналын худалдан авах үнийг 47 /дөчин долоо/ төгрөг байхаар, хугацааг санал гаргаснаас хойш 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийг дуустал байхаар тогтоосугай.
3. “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам”-д нийцүүлсэн Худалдан авах саналд Компанийг төлөөлөн гарын үсэг зурах, Санхүүгийн зохицуулах хороо, Арилжаа эрхлэгч байгууллага, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон олон нийтэд хүргүүлэх, шаардлагатай баримт бичигт гарын үсэг зурах бүрэн эрхийг Компанийн Дотоод Аудит Хариуцсан Захирал Ц.Оюунцэцэг /РД: ХЕ64012867/-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ХУЛАН

811D0UPY230005

2023-02-02

сарын

өдөр

Дугаар

Улаанбаатар хот

ТӨЛБӨРИЙН БАТАЛГАА

"ТАВАНБОГД ТРЕЙД ХХК" (цаашид "Гүйцэтгэгч" гэх) болон "САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО" (цаашид "Үүрэг гүйцэтгүүлэгч" гэх) нар 2023 оны 02 сарын 02-н өдөр
01А-56 тоот МОН БИЙФ ХК-н ХУВЬЦАА АВАХ тоот МОН БИЙФ ХК ХУВЬЦАА санал (цаашид
"санал" гэх) хүргүүлсэнтэй ХОЛБОГДУУЛАН.

Гүйцэтгэгч үүргээ биелүүлэх баталгаа болгож дор дурдсан дүнтэй банкны баталгааг
Үүрэг гүйцэтгүүлэгчид ирүүлэхийг шаардсантай ХОЛБОГДУУЛАН,

ГОЛОМТ БАНК (цаашид "Банк" гэх) нь дараах баталгааг гаргаж байна:

Банк гүйцэтгэгчийн өмнөөс 2,077,400,000.00 MNT (Хоёр тэрбум далан долоон сая дөрвөн зуун
мянган тогрөг) - оос хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө харуцаж,
гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай үүрэг гүйцэтгүүлэгчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг
хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж энэхүү баталгааг
гаргаж байна. Ингэхдээ дээрх мөнгөн дүнгийн хүрээнд гаргасан үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагад
ямарваа нэгэн нотолгоо, үндэстэл болон тайлбар шаардахгүй.

Энэхүү Баталгаа нь 2023-03-19 -ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

Энэхүү Баталгааны дагуух аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж Баталгаа гаргагчид
хүргэсэн байх ёстой.

Энэхүү Баталгааг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

Хүндэтгэсэн,

**БАЙГУУЛАГЫН БАНКНЫ ГАЗРЫН
ЗАХИАРАЛ**

